



**БАЯНТАЛ СУМЫН 14  
ХОНОГИЙН МЭДЭЭ  
2022.03.14-03.28**

ᠪᠠᠶ᠋ᠠᠨᠲᠠᠯ ᠰᠤᠮᠤ ᠶ᠋ᠢᠨ  
ᠬᠣᠨᠣᠭᠢᠶ᠋ᠢᠨ ᠮᠡᠳᠡᠭᠡ  
ᠲᠡᠭᠦᠨ ᠲᠤᠰᠤᠨ  
ᠰᠤᠮᠤ



# Удирдлага зохион байгуулалтын ажлын хүрээнд:

Монгол цэргийн өдөр Зэвсэгт хүчний 101 жилийн ойн баярыг тохиолдуулан сумын залуучуудын дунд "Цэрэг спортын цогцолбор тэмцээн"-ийг 2022 оны 03 дугаар сарын 17-ны өдөр Иргэдийн төлөөлөгчдийн хурал болон ЗХ-ний 011-р Баянтал дахь аэродромын анги хамтран зохион байгуулав. Тус тэмцээнийг 4 төрлийн зохион байгуулж, 14 тамирчид оролцон хурд, хүч, авхаалж самбаагаа сорив

1-р байранд: Сумын хэсгийн төлөөлөгч, Ахмад Х.Пүрэвжаргал  
2-р байранд: Олон нийтийн цагдаа Г.Зулхүү  
3-р байранд: ЗХ-ний 011-р ангийн Баянтал дахь Аэродромын ангийн захирагч П.Цэдэв-Отгон нар тус тус шалгаран өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнагдлаа.

Мөн Зэвсэгт хүчний анги, салбаруудад олон жил үр бүтээлтэй ажилласныг үнэлэн 011-р ангийн ажилтан Р.Бат-Эрдэнийг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаас өргөмжлөл, мөнгөн шагналаар шагналаа.



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠴᠡᠷᠭᠢᠨ ᠥᠳᠦᠷ ᠵᠡᠪᠰᠡᠭᠲᠦ ᠬᠦᠴᠢᠨ 101 ᠵᠢᠯᠢᠶᠢᠨ ᠣᠶᠢ



# Соёл урлагийн үйлчилгээ:

МУСТА, Аймгийн гоц мэргэн, морь бөх цоллооч Д.Самданбазарын эмчилгээнд зориулсан “Сэтгэлийн өргөл” хандивын тоглолтыг зохион байгуулж 158 үзэгч уг тоглолтыг үзэж хандив өргөлөө.



Монгол цэргийн өдөр, орчин цагийн зэвсэгт хүчин байгуулагдсаны 101 жилийн ойд зориулсан “Бид мартахгүй” дуун цэнгүүнд нийт 30 хүн хамрагдсан.



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠴᠡᠷᠭᠢᠨ ᠥᠳᠦᠷ, ᠣᠷᠴᠢᠨ ᠴᠠᠭᠢᠨ ᠵᠡᠪᠰᠡᠭᠲᠦ ᠬᠦᠴᠢᠨ ᠪᠠᠶᠢᠭᠤᠯᠠᠭᠳᠤᠰᠠᠨᠢ 101 ᠵᠢᠯᠢᠶᠢᠨ ᠣᠶᠳᠤ ᠵᠣᠷᠢᠭᠤᠯᠤᠰᠠᠨ “ᠪᠢᠳ ᠮᠠᠷᠲᠠᠬᠤᠭᠢ” ᠳᠤᠭᠤᠨ ᠴᠡᠩᠭᠦᠨᠳᠤ ᠨᠢᠶᠲᠤ 30 ᠬᠦᠮᠠᠷᠠᠭᠳᠠᠰᠠᠨ.











# Боловсролын ажлын хүрээнд:

“Морин хуурын дугуйланд”- 17 сурагч, “Гар бөмбөгийн дугуйланд”- 17 сурагч, “Гар зургийн дугуйланд”-17 сурагч, “Англи хэлний дугуйланд”-15 сурагч тус тус хамрагдаж байна. Нийт сурагчдын 38% буюу 59 сурагч дугуйланд хамрагдан хөгжиж байна.



ЕБСургуулийн дэргэдэх эцэг эхийн зөвлөл нь сургуулийн эмчтэй хамтран ажилтан, албан хаагчдын хүүхдүүдэд эрүүл мэндийн үзлэгт хамруулах ажлыг зохион байгуулав.



Боловсролын ажлын хүрээнд



# Боловсролын ажлын хүрээнд:

Тусгай хэрэгцээт сурагчдад зориулсан сургалтын танхимыг тохижуулан үйл ажиллагаанд оруулаад байна. Сургуульд тусгай хэрэгцээт 8 сурагч суралцдаг. Үүнээс эр-5, эм-3 бага ангийн-5, дунд ангийн-3 сурагч байна. Мөн тус танхимд шаардлагатай байгаа телевизийг Засаг даргын зөвлөлд танилцуулан Засаг даргын нөөц хөрөнгөөс авч өгөхөөр шийдвэрлэв.



2022 оны 03 дугаар сарын 22-ны өдөр аймгийн Засаг дарга Батзам, БШУГ-ын дарга А.Зургаанжин нар Баянтал сумын боловсролын байгууллагын багш ажилтан, албан хаагчидтай биечлэн уулзаж хийж хэрэгжүүлж буй ажлын талаар сонсож тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх тал дээр цаашид хамтран ажиллахаар боллоо. Мөн компьютер техник хэрэгслийг гардуулан өглөө.




Боловсролын ажлын хүрээнд



# Коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд:

03-р сарын 24-ний байдлаар амбулторын үзлэг-205, PCR шинжилгээнд- 12 иргэн Хэвтэн эмчлүүлж байгаа- 6, ойрын хавьтал-7, түргэвчилсэн оношлуураар- 28 иргэн нийт 40 иргэн КОВИД-19 цар тахалын шинжилгээнд хамрагдсан байна.

Шинжилгээ авсан байдал



ᠭᠣᠪᠢᠰᠦᠮᠪᠦᠷ





# АНХААРАЛ ХАНДУУЛСАН ТАНД БАЯРЛАЛАА

Баянтал сумын 14 хоногийн мэдээ